



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/79/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Б.Алтанзул Утас: 70523020 Цахим хаяг: altanzulb@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2022.02.28 № 46/222

танай _____ -ны № _____ -т

САЙХАНДУЛААН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Т.ГАНБАТ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сайхандулаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Төрийн албан хаагчийн байрны 8 өрөөг түрээсийн гэрээгүйгээр түрээслүүлсэн байна. Мөн орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлсний төлбөр 1.9 сая төгрөгийг аймгийн Түрээсийн орлогын дансанд дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль, "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 3.10-т "Түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд, 50 хувийг сар бүр аймгийн Түрээсийн орлогын 100060000953 тоот дансанд төвлөрүүлж, улирал бүр тооцоо нийлж байна" гэж заасныг зөрчсөн байна.
2. Орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлсний төлбөр 1.9 сая төгрөгийг байгууллагын нэмэлт орлогын дансанд дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль, "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам"-ын 3.10-т "Түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд төвлөрүүлж, улирал бүр тооцоо нийлж байна" гэж заасныг зөрчсөн байна.
3. Нэмэлт санхүүжилтийн дансаар иргэн аж ахуй нэгжээс 2.8 сая төгрөгийн хандивын орлогыг хүлээн авсан байна. Энэ нь "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын 2.3-т "Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 17.1-д "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага,

0100200:4

нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

4. Засгийн газраас айл өрхийн усны төлбөрийг чөлөөлсөн төлбөр 3.0 сая төгрөгийг өвсний зардалд зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 211-р тогтоолтой нийцэхгүй байна.
5. Нэмэлт санхүүжилтын дансны 1.5 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна. Энэ нь "Төсвийн тухай" хуулийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг буруу илэрхийллийн түвшнийг 4.6 сая төгрөгөөр тогтоосон. Аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг буруу илэрхийллийн түвшнээс 6.6 сая төгрөгөөр давсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	28.1	29.6
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,481.3	1,482.0
Нийт хөрөнгийн дүн	1,509.4	1,511.6
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,509.4	1,511.6
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,509.4	1,511.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	545.8	414.8
Үйл ажиллагааны зардлын дүн	380.7	412.6
Үйл ажиллагааны үр дүн	165.0	2.2
Үйл ажиллагааны бус үр дүн	0	0
Үйл ажиллагааны нийт үр дүн	165.0	2.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	350.3	312.8
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	345.9	310.5
Үйл ажиллагааны ЦМГ	4.4	2.3
Хөрөнгө оруулалтын ЦМГ	4.4	2.3
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
Тайлант оны үр дүн	-	2.2
Эцсийн үлдэгдэл	1,509.4	1,511.6
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	302.8	289.7
Урсгал зардал	302.8	289.7
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	302.8	289.7
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	289.0
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	0.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газрын эрхэм зорилго:

Сумын эдийн засаг нийгмийг хөгжлийг тогтвортой ахиулах үйл ажиллагааг багийн зарчмаар гүйцэтгэх мэргэшсэн албан хаагчдаас бүрдсэн чадварлаг баг болох

Зорилт: Төрийн албан хаагчийн нөөц бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах " Төрийн албан хаагчийг дэмжих жил" болгон ажиллах зорилт дэвшүүлэн ажиллах.

Сайхандулаан сумын Засаг даргын тамгын газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах;
- Засаг даргын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах;
- Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах;
- Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох;
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;
- Тухайн шатны Хурлын хэвийн үйл ажиллагааг ханган үйлчлэх;

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгаас хамгаалах дотоод хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 2.3-т “Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ” гэж заасныг зөрчин тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд иргэн, ААНБ-аас нийт 2.8 сая төгрөгийн хандив хүлээн аван, зарцуулсан байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 44.6 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 33.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 3.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа

Барилга байгууламж, орон сууц дансанд 5.5 сая төгрөгийн, Тээврийн хэрэгсэл дансанд 10.1 сая төгрөгийн, машин тоног төхөөрөмжийн дансанд 6.7 сая төгрөгийн, Тавилга эд хогшил дансанд 0.9 сая төгрөгийн, бусад үндсэн хөрөнгө дансанд 10.3 сая төгрөгийн нийт 33.5 сая төгрөгийн элэгдлийг дутуу тооцсоныг, урд оны нийгмийн даатгалын авлагыг шууд зардалд хаасанг залруулав.

Төлбөрийн акт

1. Төрийн албан хаагчийн байрны 8 өрөөг түрээсийн гэрээгүйгээр түрээслүүлсэн байна. Мөн орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлсний төлбөр 1.9 сая төгрөгийг аймгийн Түрээсийн орлогын дансанд дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 3.10-т “Түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд, 50 хувийг сар бүр аймгийн Түрээсийн орлогын 100060000953 тоот дансанд төвлөрүүлж, улирал бүр тооцоо нийлж байна” гэж заасныг зөрчсөн байна.
2. Орон нутгийн өмч хөрөнгийг түрээслүүлсний төлбөр 1.9 сая төгрөгийг байгууллагын нэмэлт орлогын дансанд дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ын 3.10-т “Түрээслүүлэгч түрээсийн орлогын 50 хувийг байгууллагын нэмэлт орлогын дансанд төвлөрүүлж, улирал бүр тооцоо нийлж байна” гэж заасныг зөрчсөн байна.

Албан шаардлага

1. Нэмэлт санхүүжилтийн дансаар иргэн аж ахуй нэгжээс 2.8 сая төгрөгийн хандивын орлогыг хүлээн авсан байна. Энэ нь “Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ын 2.3-т “Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.
2. Засгийн газраас айл өрхийн усны төлбөрийг чөлөөлсөн төлбөр 3.0 сая төгрөгийг өвсний зардалд зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 211-р тогтоолтой нийцэхгүй байна.

Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 1.1 Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 187.6 сая төгрөгийн 263 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 31.1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэж заасантай нийцэхгүй байна.
- 1.2 Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, эсхүл дахин шинээр үнэ тогтоож, ашиглалтын байдлыг тодорхой болгох

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Орлогын гүйлгээг журнал бичилттэй тулган шалгахад хандивын орлогыг тухай бүр нэр төрлөөр бүртгээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Шилдэг сумаар шалгарсан шагналын 1.5 сая төгрөгийг анхан шатны баримтгүйгээр зарцуулсан байна..

3.2 Өгсөн зөвлөмж: “Төсвийн тухай” хуулийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, гүйлгээ хийхдээ и-баримтын бүрдлийг хангаж ажиллах

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	44.6	2	33.5	2	3.8	2	5.8	3	1.5
	НИЙТ	9	44.6	2	33.5	2	3.8	2	5.8	3	1.5